

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар

| № | Гарчиг | Авбал зохих нийт оноо | Үнэлсэн оноо | Хяналтын оноо | Үнэлгээний хувь |
|--------------------|--|--------------------------|--------------|------------------|-----------------|
| 1 | ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт | 12 | 10 | | 83.3% |
| 2 | ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг | 10 | 10 | | 100% |
| 3 | Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал | 6 | 6 | | 100% |
| 4 | Аудит, хяналтын тогтолцоо | 6 | 6 | | 100% |
| 5 | Эрсдэлийн удирдлага | 8 | 8 | | 100% |
| 6 | Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал | 6 | 6 | | 100% |
| 7 | Оролцогч талуудын эрх ашиг | 8 | 8 | | 100% |
| 8 | Компанийн соёл | 6 | 6 | | 100% |
| 9 | Хувьцаа эзэмшигчдийн эрх | 10 | 10 | | 100% |
| Нэгдсэн дүн | | 72 | 70 | | 97.2% |

Тайлбар: 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар “ЛэндМН ББСБ” ХК нь "Компанийн засаглалын кодекс"-ийг 97.2%-тай хэрэгжүүлэн ажиллаж, “Засаглал хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд үнэлэгдлээ.

2. 2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДРИЙН БАЙДЛААРХ “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

| НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ | | | |
|--|---|-----------|--|
| Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна | | | |
| | | Хэрэгжилт | Хэрхэн хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй талаарх тайлбар |
| 1 | <i>1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i> | 2 | <p>“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) нь Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн Үйл ажиллагааны журмыг 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 18/13 тоот тогтоолоор батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p> <p>Мөн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг Компанийн Засаглалын Кодекс (цаашид “КЗК”)-ын хэрэгжилтийн хүрээнд шинэчлэн боловсруулсан бөгөөд уг төслийг Компанийн ТУЗ-ийн 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлаар батлан мөрдөж эхэлнэ.</p> |
| 2 | <i>1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.</i> | 2 | <p>Компани нь ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмаар нэр дэвшүүлэх, залгамж халааны бодлогыг зохицуулж байсныг КЗК-д нийцүүлэн бие даасан баримт бичиг болгох арга хэмжээ авсан.</p> <p>Уг төслийг ЛэндМН-ийн ТУЗ-ийн 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлаар батлан мөрдөж эхэлнэ.</p> |
| 3 | <i>1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.</i> | 2 | <p>Компанийн Жилийн үйл ажиллагааны тайланд тусгах арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд Компанийн цахим хуудсанд байршуулсан.</p> <p>https://lend.mn/postdynamic.html?article=3638549176449633912 Жилийн үйл ажиллагааны тайлангийн 35-39-р хуудсыг үзнэ үү.</p> |

| | | | |
|--|--|----------------------|--|
| 4 | <i>1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.</i> | 2 | Компани нь ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмаар тус асуудлыг зохицуулж байна. Тодруулбал, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3-8-р бүлгээр зохицуулсан бөгөөд өдөр тутмын ажиллагаандаа мөрдөж байна. |
| 5 | <i>1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i> | 2023 оны 4-р улиралд | Бид Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход өгөх гарын авлага боловсруулахаар ажиллаж байна. Мөн 2023 оны 4-р улиралд багтаан ТУЗ-ийн гишүүдэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг шинэчлэх сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж, холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. |
| 6 | <i>1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i> | 2 | ТУЗ-ийн нарийн бичгийн даргын 2022 оны ажлын тайланг бэлтгэж, хүргүүлэв. |
| ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ | | | |
| 7 | <i>2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i> | 2 | Компанийн ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд эдгээрээс 3 нь хараат бус гишүүн, үлдэж буй 6 гишүүний 2 нь Компанитай сонирхлын зөрчилгүй буюу Компани, түүний охин компани, Компанийн толгой болон бусад хамаарал бүхий компанитай холбоо хамааралгүй гишүүд болно. |
| 8 | <i>2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i> | 2 | Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Жаргалсүрэн ажиллаж байна. Компанийн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам"-ын 10.12 - 10.19, мөн 10.20 - 10.30 дугаар зүйлээр Аудитын хорооны үйл ажиллагааны нөхцөл журам болон |

| | | | |
|---|--|---|---|
| | | | <p>бодлогыг тодорхойлдог. Компанийн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 6.2 болон 10.13-т заасны дагуу Аудитын хорооны 2/3 нь хараат бус гишүүд байх ба мөн журмын 10.13-д зааснаар хорооны гишүүд нь санхүү тайлагнал буюу нягтлан бодох бүртгэл, аудитын чиглэлээр мэргэшсэн байхыг шаарддаг.</p> <p>Түүнчлэн, Аудитын хороо нь Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10.14-т зааснаар санхүүгийн мэдээллийн болон нягтлан бодох бүртгэлийн асуудлаар дотоод болон хөндлөнгийн аудиттай харьцаж, 10.17-д заасны дагуу зөвхөн ТУЗ-д үйл ажиллагаагаа тайлагнана.</p> <p>Аудитын хорооны хуралд гишүүд, нарийн бичгийн дарга нар оролцдог ба Аудитын хорооноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудыг оролцуулдаг.</p> <p>Мөн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 10.12-т зааснаар тус хороо нь Компанийн бүхий л үйл ажиллагаанд хяналт тавих, хөндлөнгийн аудитыг сонгох, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих зэрэг цогц үйл ажиллагааг хэрэгжүүлж, Компанийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэх чиглэлээр бодлого тодорхойлон ажиллаж байна.</p> |
| 9 | <p>2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</p> | 2 | <p>Компанийн ТУЗ-ийн дэргэд Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо (цаашид “ЗНДЦУ”) гэж байдаг бөгөөд Компанийн цалин урамшуулал, засаглал болон нэр дэвшүүлэх үйл ажиллагааг хамтад нь хариуцан гүйцэтгэж байна.</p> <p>ЗНДЦУ хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн С.Энх-Амгалан ажиллаж байгаа бөгөөд тэрээр ТУЗ-ийн дарга</p> |

| | | | |
|----|--|---|--|
| 10 | <p>2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</p> | 2 | <p>биш, түүнчлэн “ЛэндМН ББСБ” ХК болон түүний нэгдлийн оролцогч, толгой болон охин компанитай холбоо хамааралгүй юм.</p> <p>ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 10.3-т заасны дагуу ЗНДЦУ хорооны $\frac{2}{3}$ нь хараат бус гишүүдээс бүрдсэн байна.</p> <p>Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10.6 - 10.11, мөн 10.20 - 10.30 дугаар зүйлээр ЗДНЦУ хорооны үйл ажиллагааны нөхцөл журам болон бодлогыг тодорхойлдог.</p> <p>Түүнчлэн, Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйл , 10 дугаар зүйлийн 10.6, 10.7, 10.11 дэх хэсгүүд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ”)-оос үлгэрчлэн баталсан залгамж халааны баримт бичигтэй бүрэн нийцэж байгаа болно.</p> <p>Мөн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10.6-д зааснаар тус хороо нь Компанийн эрх бүхий албан тушаалтнуудыг томилох, чөлөөлөх, тэдгээрт тавигдах шаардлагыг тодорхойлох, нэрсийн жагсаалт гарган хөтлөх, эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх, зэрэг цогц үйл ажиллагааг хэрэгжүүлж, Компанийн эрх бүхий албан тушаалтны аливаа томилгооны залгамж халааг үргэлжлүүлэн ажиллаж байна.</p> <p>Мөн Залгамж халааны бодлогыг Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйл , 10 дугаар зүйлийн 10.6, 10.7, 10.11 дэх хэсгүүд зохицуулж байсныг КЗК-д нийцүүлэн бие даасан баримт бичиг болгох арга хэмжээ авсан.</p> |
|----|--|---|--|

| | | | |
|--|---|---|---|
| | | | Уг төслийг ЛэндМН-ийн 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлаар батлан мөрдөж эхэлнэ. |
| 11 | <i>2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</i> | 2 | Одоогийн байдлаар Компанийн ТУЗ нь: 1. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 2. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо 3. ТУЗ-ийн дэргэдэх ЗДНЦУ хороо гэсэн 3 хороотойгоор үйл ажиллагаа явуулж байна. ТУЗ-ийн гишүүдийн хувьд хороодын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлагатай болно. 2023 оны ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц бүрэлдэхүүнийг 2023 оны эхний хагас жилийн тайлангийн 38-р хуудаснаас үзнэ үү: https://lend.mn/postdynamic.html?article=8681082997033297279 |
| ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ | | | |
| Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн байдлыг хангана | | | |
| 12 | <i>3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i> | 2 | ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмаар зохицуулж байсныг КЗК-д нийцүүлэн бие даасан баримт бичиг болгох арга хэмжээ авсан. Уг төслийг ЛэндМН-ийн ийн 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлаар батлан мөрдөж эхэлнэ. |
| 13 | <i>3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i> | 2 | https://lend.mn/aboutus.html тус хуудасны хамгийн доод талын “дүрэм журам” хэсэгт мэдээллүүдийг оруулсан болно. |
| 14 | <i>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн</i> | 2 | Компанийн улирал болон жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд санхүүгийн мэдээллийг хуульд заасан агуулга, хэлбэрийн хүрээнд, санхүүгийн |

| | | | |
|---|---|---|---|
| | <i>хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</i> | | бус тайлагналыг хувьцаа эзэмшигчид, олон нийтэд ойлгомжтой, холбогдох тайлбарын хамтаар тухай бүр тайлагнаж байна. Санхүүгийн бус тайлагналын агуулгыг хамгийн сүүлийн тайлан буюу 2023 оны эхний хагас жилийн тайлангийн 5-7-р хуудас, 22-23-р хуудас, 27-р хуудас, 33-р хуудаснаас үзнэ үү. https://lend.mn/postdynamic.html?article=8681082997033297279 |
| ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана | | | |
| 15 | <i>4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.</i> | 2 | Компанийн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 10.12 - 10.19, мөн 10.20 - 10.30 дугаар зүйлээр Аудитын хорооны үйл ажиллагааны нөхцөл журам болон бодлогыг тодорхойлдог ба тэдгээр нь СЗХ-оос үлгэрчлэн баталсан дотоод хяналт, дотоод аудитын баримт бичигтэй бүрэн нийцэж болно. Аудитын хороо нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10.14.1-т зааснаар “Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох, уг байгууллагаас хийх шалгалтын болон гаргах дүгнэлтийн чиглэлийг тогтоох талаар санал боловсруулах”, 10.6-д зааснаар Аудитын хороо нь санхүүгийн мэдээллийн болон нягтлан бодох бүртгэлийн асуудлаар хөндлөнгийн аудитор болон дотоод хяналтын албатай байнга санал солилцох” гэсэн үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| 16 | <i>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</i> | 2 | Компанийн 2022 оны ХЭХ-д Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу сонгогдон ажилласан “Монголын |

| | | | |
|---|---|---|--|
| | | | Үндэсний Тайлагнал Аудит” ХХК-ийн аудиторууд оролцсон болно. |
| 17 | <i>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.</i> | 2 | <p>Компанийн одоогийн Дотоод аудитор 2020 онд томилогдсон, түүнчлэн аудитын дотоод бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг мэдээлж байсан. Хамгийн сүүлийн байдлаар Компанийн зүгээс 2022 оны жилийн тайлан болон 2023 оны эхний хагас жилийн тайланд энэ тухай дэлгэрэнгүй мэдээлсэн.</p> <p>2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан https://lend.mn/postdynamic.html?article=3638549176449633912 39-р хуудсаас үзнэ үү.</p> <p>2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан https://lend.mn/postdynamic.html?article=8681082997033297279 42-р хуудсаас үзнэ үү.</p> |
| ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА | | | |
| Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина | | | |
| 18 | <i>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.</i> | 2 | <p>Компанийн зүгээс Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 06- ны өдөр баталсан “Эрсдэлийн удирдлагын бодлого”-оо шинэчлэн баталсан ба ажиллагаандаа нягт мөрдөн ажиллаж байна. Тус бодлогын 3 дугаар зүйлийн 3.3-т зааснаар Компани нь эрсдэлийн 3 давхар хамгаалалтын бүсийг хэрэгжүүлж, улирал бүр ТУЗ-ийн хуралд Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрсдэл, хянан нийцүүлэлтийн газраас эрсдэлийн талаар тайлагнан ажилладаг.</p> <p>Ингэснээр Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн компанид учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, түүнийг хэрхэн удирдах талаар бодит, бүрэн ойлголттой болж, хяналт тавин ажилладаг.</p> |

| | | | |
|----|---|---|--|
| 19 | <p>5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</p> | 2 | <p>Эрсдэлийн удирдлагын бодлогод заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь Компанийн эрсдэлийн бодлогыг баталж, хүлээн зөвшөөрөгдсөн эрсдэлийн хэм хэмжээ, эрсдэлийн төрөл, хязгаарыг тодорхойлж, улирал тутамд тогтмол хянаж, эрсдэлийг хянах, илрүүлэх дотоод хяналтын тогтолцооны үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, холбогдох зөвлөмжийг ТУЗ-д танилцуулдаг.</p> <p>Компанид тулгарч байгаа эрсдэл, тэдгээрийг хэрхэн удирдаж байгаа талаар бүрэн гүйцэд мэдээллийг гүйцэтгэх удирдлагаас ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол улирал тутамд хүргүүлэн заавар, удирдамж авдаг.</p> <p>ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хэрэгжилтийн талаарх мэдээллийг улирал болон жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж, цахим хуудсанд байршуулдаг.</p> <p>2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан https://lend.mn/postdynamic.html?article=3638549176449633912 28-29-р хуудас болон 36-р хуудсаас үзнэ үү.</p> |
| 20 | <p>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</p> | 2 | <p>Компани нь бичил хэрэглээний зээл гар утсан дээр суурилж олгодог тул байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын хүрээний эрсдэлүүд бага тул зээл олголт тус бүрд БОНЭҮ үнэлгээ хийх шаардлагагүй байдаг. Харин компани нь 2021 оноос автомашины зээл олгож эхэлсэн бөгөөд тус зээлийг зөвхөн байгаль орчинд ээлтэй, цахилгаан хөдөлгүүрт автомашиныг санхүүжилтэд олгодог.</p> <p>Компани нь энэ зөвлөмжид дурдсан мэдээллийг тайлагнахдаа заавал бие даасан тогтвортой байдлын тайлан гаргах үүрэггүй боловч олон улсад хүлээн</p> |

| | | | |
|--|--|---|---|
| | | | <p>зөвшөөрөгдсөн стандартын дагуу тогтвортой байдлын тайланг хэсэгчилсэн байдлаар гаргаж, финтекийн үйл ажиллагаа эрхэлснээр жилд хэдий хэмжээний цаас болон мод хэмнэсэн талаар тайлан гаргаж жилийн үйл ажиллагааны тайлан дээр тусгаж олон нийтэд мэдээлдэг.</p> <p>2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан https://lend.mn/postdynamic.html?article=3638549176449633912 16-17-р хуудсаас үзнэ үү.</p> |
| 21 | <i>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.</i> | 2 | <p>Эрсдэлийн удирдлагын бодлогын 3 дугаар үйл, 4 болон 7 дугаар зүйлд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын зүгээс комплайнсын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж буй нэгж - ажилтныг шаардлагатай туслалцаа, дэмжлэгийг үзүүлж, бие даасан хараат бус байдлыг хангадаг бөгөөд Гүйцэтгэх захирлын тушаалаар комплайнсын ажилтныг томилон ажилладаг.</p> |
| ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ | | | |
| Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна | | | |
| 22 | <i>6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i> | 2 | <p>Компани нь жил бүрийн ээлжит ХЭХ-аар ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох сар, түүнчлэн бусад зардлын зүйлийг нэг бүрчлэн тусгасан төсвийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулсны үндсэн дээр ээлжит ХЭХ-аар ил тод хэлэлцэж баталдаг.</p> <p>Жишээлбэл, 2023 оны ТУЗ-ийн төсвийг ээлжит ХЭХ-ын материалд тусгаж, нээлттэй хэлэлцэж баталсан байдаг.</p> |
| 23 | <i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.</i> | 2 | <p>Компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан “Цалин, хөлс, хөнгөлөлт, хангамж, урамшуулал тооцож олгох тухай журам”-ын дагуу Компанийн ажилчдын цалин, урамшууллыг Компанийн үйл</p> |

| | | |
|--|--|---|
| | | <p>ажиллагаа, ажлын байрны онцлогт тохируулан үндэслэл бүхий, шударгаар тооцон олгож байна.</p> <p>Жишээлбэл, тус журмын 2 дугаар зүйлийн 2.1.1-т Компанийн хэмжээнд нийт ажилтнуудын цалин, урамшуулал нь хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц байна. Өрсөлдөхүйц цалин хөлсийг хөдөлмөрийн зах зээл дэх цалин, урамшууллын тархацтай жишиж тогтооно гэж заасан. Мөн тухайн жилийн улс орны инфляцын өсөлттэй уялдуулан цалин хөлсийг Гүйцэтгэх захирлын шийдвэрээр өөрчил болох тухай тус журамд тусгасан.</p> <p>Журамд үндсэн цалин тогтоох, ур чадварт суурилсан нэмэлт цалин, хавсран буюу орлон ажилласны нэмэлт цалин, илүү цаг тооцох, амралтын болон нийтгээр амрах баяр ёслолын үеэр ажилласны цалин тооцох гэх мэт цалин хөлс тооцох, хэмжээг тогтоох талаар дэлгэрэнгүй, ил тодоор тусгасан байдаг.</p> <p>Түүнчлэн, Компанийн ажилтнуудад тухайн жилийн гүйцэтгэлийн үнэлгээнээс хамаарч урамшуулал буюу бонус олгодог. Урамшууллыг тооцохдоо олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн SMART зарчмыг баримтлах ба ажилтны гүйцэтгэлээс цалингийн 120% хүртэл хэмжээний бонус олгох боломжтой байдаг. Эдгээртэй холбоотой харилцааг Компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан Гүйцэтгэлийн үнэлгээний журмын дагуу зохицуулж байна. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд буюу гүйцэтгэх удирдлага, гүйцэтгэх удирдлагын түвшний цалин хөлс, урамшууллыг Компанийн ТҮЗ-ийн дэргэдэх ЗНДЦУ-оос тухай бүр тогтоон ажиллаж байна.</p> |
|--|--|---|

| | | | |
|---|--|---|--|
| 24 | 6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана. | 2 | <p>Компани нь 2022 оны жилийн үйл ажиллагааны тайланд Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын бодлогын талаар тусган нийтэд мэдээлсэн болно.</p> <p>2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан https://lend.mn/postdynamic.html?article=3638549176449633912 42-р хуудсаас үзнэ үү.</p> |
| ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ | | | |
| 25 | 7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ. | 2 | <p>Компани нь ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 19/54 тоот тогтоолоор батлагдсан Ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p> <p>Тус журмын 3.4-т “харилцагч, бизнесийн түншүүдтэй харилцах харилцаанд баримтлах ёс зүйн стандарт”, 3.6-д “нийгэм, олон нийттэй харилцах харилцаанд баримтлах ёс зүйн стандарт” зэргийг тусгайлан зохицуулсан бөгөөд оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлэн ажиллаж байна.</p> <p>Ёс зүйн дүрэмтэй дараах холбоосоос танилцана уу https://lend.mn/files/%D0%81%D1%81%20%D0%B7%D2%AF%D0%B9%D0%BD%20%D0%B4%D2%AF%D1%80%D1%8D%D0%BC.pdf</p> |
| 26 | 7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана. | 2 | <p>Компани нь 2022 оны жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгасан болно.</p> <p>2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан https://lend.mn/postdynamic.html?article=3638549176449633912 32-р хуудсаас үзнэ үү.</p> |

| | | | |
|---|---|---|---|
| 27 | 7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна. | 2 | <p>Компанийн цахим хуудсыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар бүрэн шинэчилсэн бөгөөд , бүтээгдэхүүн үйлчилгээний дэлгэрэнгүй нөхцөл, компанийн хувьцааны мэдээлэл, компанийн бүтэц, компанийн мэдээлэл, компанитай харилцах холбогдох хаяг, утас зэргийг шинэчлэн оруулсан.</p> <p>Жишээлбэл, хэрэглэгч ажлын өдрүүдэд 09-18 цагийн хооронд харилцагчийн үйлчилгээний 77070101 утсаар холбогдох, facebook messenger ашиглан хүссэн үедээ холбогдох боломжтой. Компанийн цахим хуудсанд "тусламж" цэсийг тухайлан байршуулсан бөгөөд Компанитай холбогдох бүхий л сувгуудыг байршуулсан болно.</p> <p>https://lend.mn/</p> |
| 28 | 7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна. | 2 | <p>Компани нь Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан Шүгэл үлээх журмаар тус харилцааг цогц байдлаар зохицуулдаг.</p> <p>Шүгэл үлээх журамтай дараах холбоосоор танилцана уу https://lend.mn/files/LendMN_Shugel_uleeh_juram.pdf</p> |
| НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно | | | |
| 29 | 8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина. | 2 | <p>Компани нь ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 19/54 тоот тогтоолоор батлагдсан Ёс зүйн дүрмээр Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлсон бөгөөд хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах суурийг бий болгосон.</p> |

| | | | |
|--|---|---|--|
| | | | <p>Мөн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын холбогдох хэсгүүдэд ТУЗ-ийн дарга, гишүүн, бусад эрх бүхий албан тушаалтнууд ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд хүлээх хариуцлагын зохицуулалтыг оруулж, шинэчилсэн төслийг бэлтгэсэн.</p> <p>Уг шинэчилсэн төслийг ЛэндМН-ийн 2023.08.03 өдрийн ээлжит хурлаар батлан мөрдөж эхэлнэ.</p> |
| 30 | <i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i> | 2 | <p>Компани нь Гүйцэтгэх захирлын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 2021/04 тоот тогтоолоор багтагдсан Шүгэл үлээх журмаар тус харилцааг цогц байдлаар зохицуулдаг.</p> <p>Шүгэл үлээх журамтай дараах холбоосоор танилцана уу https://lend.mn/files/LendMN_Shugel_uleeh_juram.pdf</p> |
| 31 | <i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i> | 2 | <p>Ёс зүйн дүрмийн 3.3 болон 3.5-д энэ талаар зохицуулсан.</p> <p>Ёс зүйн дүрэмтэй дараах холбоосоос танилцана уу https://lend.mn/files/%D0%81%D1%81%20%D0%B7%D2%AF%D0%B9%D0%BD%20%D0%B4%D2%AF%D1%80%D1%8D%D0%BC.pdf</p> |
| <p>ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</p> <p>Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана</p> | | | |
| 32 | <i>9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.</i> | 2 | <p>Компани нь өөрийн цахим хуудсанд мэдээ мэдээлэл, тайлангуудыг цаг тухай бүр оруулан хүргэж байна.</p> <p>Компанийн цахим хуудасны мэдээ мэдээлэл хэсэгтэй дараах холбоосоос танилцана уу https://lend.mn/news.html</p> |

| | | | |
|----|---|---|---|
| 33 | <p>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</p> | 2 | <p>Компани Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн төслийг боловсруулсан.</p> <p>Уг төслийг ЛэндМН-ийн 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлаар батлан мөрдөж эхэлнэ.</p> |
| 34 | <p>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</p> | 2 | <p>Компани нь жил бүрийн ээлжит ХЭХ-ыг СЗХ-ны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ ЖУРАМ” болон тус журамд СЗХ-оос 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 45 тоот тогтоолоор оруулсан нэмэлт, өөрчлөлт (ХУРЛЫГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХ)-үүдийг мөрдлөг болгон зохион байгуулж байна.</p> <p>Компани нь 2019, 2020, 2021 оны ээлжит ХЭХ-ыг цахим хэлбэрээр, 2022 ээлжит ХЭХ-ыг танхимын хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд ингэхдээ хурлын зарыг 40-өөс доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдэд брокер, диллерийн компаниудаар дамжуулан хүргүүлж, мөн цахимаар бэлтгэн Компанийн цахим хуудас болон бусад сошиал орчинд нээлттэй байршуулсан.</p> <p>Түүнчлэн, дээр дурдсан журамд заасны дагуу хуралд биечлэн оролцохгүйгээр урьдчилан бичгээр санал өгөх нөхцөлийг бүрдүүлсний сацуу хурлын өдөр хувьцаа эзэмшигч өөрийн бүртгэлээр нэтрэн орж ХЭХ-д оролцох, санал өгөх зориулалт бүхий тусгайлсан веб буюу зайны технологийг хөгжүүлж, уг хурлуудад амжилттай ашигласан</p> <p>Ээлжит ХЭХ-д оролцох, саналаа өгөх, хэлэлцэж буй асуудлаар санал оруулах зэрэг мэдээллийг Компанийн Харилцагчийн үйлчилгээний төвөөр дамжуулан,</p> |

| | | | |
|-------------|---|-----------|--|
| | | | <p>шаардлагатай тохиолдолд Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хуульчидтай шууд холбон мэдээлэл өгч ажилласан байна.</p> <p>Ээлжит ХЭХ-ын шийдвэр, холбогдох баримт бичгийг тухай бүр СЗХ болон Монгол Хөрөнгийн Биржид хүргүүлсэн болно.</p> |
| 35 | <i>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</i> | 2 | <p>Компанийн үйл ажиллагааны чиглэл нэмэх, хасах, тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрлэх эсэх, компанийн хэлбэрийг өөрчлөх, Компанийг нэгтгэх, нийлүүлэх, хуваах зэргээр өөрчлөн байгуулах гэх мэт асуудлыг зөвхөн ХЭХ-аар буюу хувьцаа эзэмшигчдийн саналын дагуу шийдвэрлэхээр Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1, 8.4.2, 8.4.4-т заасан байдаг.</p> <p>Түүнчлэн Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.3-т зааснаар хувьцаа нэмж гаргах, хувьцаа эзэмшигчд түүнийг тэргүүн ээлжид худалдан авах эсэх асуудлыг мөн зөвхөн ХЭХ-аар буюу хувьцаа эзэмшигчдийн саналын дагуу шийдвэрлэхээр заасан.</p> |
| 36 | <i>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</i> | 2 | <p>Компани нь Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх тухай журмыг боловсруулсан.</p> <p>Уг төслийг ЛэндМН-ийн 2023 оны 08 дугаар сарын 03-ны ээлжит хурлаар батлан мөрдөж эхэлнэ.</p> |
| Нийт | | 70 | 97.2% |